

Российская академия наук  
Институт восточных рукописей  
(Азиатский Музей)



# MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXV • 2022 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Адрес учредителя: 191186,  
г. Санкт-Петербург,  
Дворцовая наб., д. 18, лит. А  
Адрес редакции: 191186,  
г. Санкт-Петербург,  
Дворцовая наб., д. 18, лит. А  
Тел.: +7 (812) 315-87-28  
<http://orientalstudies.ru>  
[mongolica@orientalstudies.ru](mailto:mongolica@orientalstudies.ru)  
[kulgan@inbox.ru](mailto:kulgan@inbox.ru)  
[dnosov@mail.ru](mailto:dnosov@mail.ru)

Свидетельство о регистрации  
средства массовой информации  
ПИ № ФС77-79202  
от 22 сентября 2020 г.  
Выдано Федеральной службой  
по надзору в сфере связи,  
информационных технологий  
и массовых коммуникаций  
(Роскомнадзор)

## Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,  
доктор филологических наук (Россия)*  
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук  
(Россия)*  
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*  
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*  
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*  
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*  
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*  
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор  
РАН (Россия)*  
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*  
В. Капишовска, *доктор наук (Чехия)*  
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*  
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*  
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*  
Р. Поп, *доктор наук (Румыния)*  
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, про-  
фессор (Россия)*  
С. Чулуун, *академик МАН (Монголия)*  
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*  
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*  
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 22.09.2022

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

*e-mail:* editor@isvov.ru

ISSN 2311-5939

DOI 10.25882/2xm5-dr90

12+

© Институт восточных рукописей РАН  
(Азиатский Музей), 2022

© Коллектив авторов, 2022

## В НОМЕРЕ:

<b>ЛИНГВИСТИКА</b> .....	5
<b>D. Zayabaatar.</b> The loss of the consonant <i>-l-</i> and syllable <i>-la/le-</i> in Mongolian .....	5
<b>ЛИТЕРАТУРОВЕДЕНИЕ И ТЕКСТОЛОГИЯ</b> .....	17
<b>А. А. Бердыева.</b> Влияние западных литературно-философских тенденций на современную литературу Республики Корея.....	17
<b>Н. В. Ямпольская.</b> К вопросу о структуре монгольских рукописных Ганджуров XVII века: тома <i>ga</i> и <i>da</i> раздела «Сутры» в списках из Аблай-хита .....	24
<b>ФОЛЬКЛОР И ЭТНОГРАФИЯ</b> .....	41
<b>А. Алимаа.</b> Халх монголчуудын хүүхдийн сэвлэг үргээх ёслолын соёлын утга өнөө цагийн байдал .....	41
<b>Б. Х. Борлыкова, Б. В. Меняев.</b> Калмыцкие песни, посвященные ойратской знати.....	51
<b>Г. Бямбарагчаа.</b> Монгольская игра в бабки на льду .....	61
<b>СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ</b> .....	67
<b>Ю. А. Иоаннесян.</b> Гератский предлог <i>ta(y)-ye / tey-ye</i> : фонетическая трансформация или контаминация двух предлогов?.....	67
<b>Н. Е. Васильева.</b> Изучение рукописи «Маджмӯ‘ ат-таварйх» и ее значение для исторической этнографии народов Средней Азии .....	74
<b>НАУЧНАЯ ЖИЗНЬ</b> .....	84
<b>О. Н. Полянская.</b> Международная научная конференция «Банзаровские чтения», посвященная 200-летию Доржи Банзарова и 90-летию БГПИ — БГУ (Россия, Улан-Удэ, 30-31 марта 2022 г.).....	84
<b>Ц. Ц. Саранцацрал.</b> “Репиний академийн шадар 3” тусгай үзэсгэлэн .....	89
<b>И. В. Кульганек.</b> Новые книги по монголоведению .....	92

Аюушжав Алимаа  
МУ ШУА-ийн Хэл зохиол хурээлэн

## ХАЛХ МОНГОЛЧУУДЫН ХҮҮХДИЙН СЭВЛЭГ ҮРГЭЭХ ЁСЛОЛЫН СОЁЛЫН УТГА ӨНӨӨ ЦАГИЙН БАЙДАЛ

Хураангуй. Өгүүлэлд монголчуудын гэр ахуйн холбогдолт зан үйлийн дотроос хүүхдийн онгон үсийг анхлан хөндөх зан үйлийн ёслолын уламжлал, залгамжийн талаар шинжилгээний ангийн баримтад түшин өгүүлжээ. Хүүхдийн үс авах (хөндөх)-ийг монголчууд сэвлэг (даахь, өрвөлөг-өрвөө) авах, үргээх гэх мэтээр янз янзаар нэрлэдэг энэхүү өвөрмөц зан үйлийн нь нэн эртний уламжлалтай бөгөөд баатарлаг туулинд тодорхой тусгалаа олжээ. Монголчууд хүүхдийн тэргүүн дэх онгон үсийг анх авахдаа шууд төмөр, ирт мэс хүргэдэггүй, эхлээд модоор хийсэн хайчаар үсийг авч буй мэт дүр үзүүлээд дараа нь бариулаас нь хадаг уясан хайч, хурц тонгорог хүүхдийн толгойн баруун талын санчигнаас эхлэн нар зөв чиглэлд тойруулан хайчлах бөгөөд эцэст нь үсийг ихэвчлэн бүрэн хусах, сонжуу буюу багц үс (тав) үлдээх байдлаар авдаг байжээ. Хүүхдийн сэвлэг үргээх ёслолд оролцож буй хүн бүр тухайн хүүхдэд ерөөл бэлгийн үг хэлж бэлэг өгнө. Хүүхдийн үсийг анх удаа авах үйлийг эцэг эхчүүд онцгойлон үзэж өдрийн сайныг сонгон гэр бүл, төрөл садан, ойр орчмын айлын хүмүүсийг уриан залж бага хэмжээний баяр хийх тул сэвлэгийн найр, даахины найр, хүүхдийн үсний найр гэнэ. Нийт монгол угсаатны дунд өргөн дэлгэрсэн энэхүү ёслол өнөө цагт Монгол улсын иргэдийн дунд ямархуу байдлаар улиран хадгалагдаж байгаа нь судлаачдын төдийгүй аман зохиолчдын хувьд анхаарлын төвд байдаг асуудал юм. Тиймээс судлаач Монгол Улсын өнөөгийн газар нутгийн байдлаар баруун халхчуудын төлөөлөл болгон Өвөрхангай аймгийн Уянга суманд хүүхдийн сэвлэг авч буй ёслолд оролцон зан үйлийн болон аман зохиолын зүйлд ажиглалт хийжээ. Үүний үр дүнд өнөө цагийн халхчуудын хүүхдийн даахь авах ёслолд нэн эрт үеийн мартагдсан элементүүд хадгалагдан үлдсэнийг баримтаар тодруулсан байна. Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын буриадуудад хийсэн судалгаанд түүнтэй уялдаа бүхий өөр нэг сонирхолтой баримтыг олж баяжуулснаа энэхүү өгүүлэлдээ дурджээ.

Түлхүүр үгс: Онгон үс, хүүхдийн онгон үс авах, сэвлэг хөндөх ёслол, монгол зан үйл, зан үйлийн аман зохиол.

Зохиогчийн тухай: Аюушжав Алимаа, Аман зохиол судлалын салбарын эрхлэгч, Монгол улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хурээлэн (Монгол Улс, 13330, Улаанбаатар, Энхтайвны өргөн чөлө, Баянзурх дүүрэг, 54А). ORCID 0000-0002-3533-2000 (alimaa\_mgl@yahoo.com).

### 1. УДИРТГАЛ

Монгол үндэстний зан үйлийн олон ёслол тэдний амьдралын мөчлөг, ертөнцийг үзэх үзэл, цаг улирал, эрхэлдэг аж ахуй, тодруулбал нүүдлийн мал ахуй, зан заншил, ёс бэлгэдэл зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай юм. Монголчуудын зан үйл, баяр ёслолыг цаг улирлын (цагаан сар, хаврын даллага, овоо тахилга, эрийн гурван наадам), мал аж ахуйтай холбогдох (төл авахуулах, мал хөнгөлөх, гүүний үрс гаргах, мал тамгалах, сэтэрлэх, нядлах), тэрчлэн ан агнуур, газар тариалантай холбогдох зэрэг байдлаар ангилж үздэг. Эдгээрийн нэг хэсэг нь гэр ахуйн буюу хүнтэй холбогдох зан үйлийн олон ёслол билээ. Гэр ахуйн холбогдолт

зан үйл гэдэг нь “нийгмийн нэг гишүүний амьдралд тохиолдсон (хүүхэд төрөх, гэрлэх, насны ой тэмдэгдэх, тадийгаачийг оршуулах) онцлог хүндэтгэлт үйл явдлыг ёслол тэмдэглэж түүнд хандах хамт олных нь ерөөн бэлгэдэх, хүндэтгэн ёслох, харуусан гашуудах зэрэг сэтгэлийн өнгө аясыг идэрхийлэхэд чиглэгдсэн уламжлалт зан заншил, аман яруу найргийн цогцолбор юм” [Сампилдэндэв, 1985. Х. 212].

Монголчуудын баримталдаг ёс заншлуудын доторх нэгэн бүлэг зан үйл нь хүүхэдтэй холбоотой. Өрх бүлд шинэ хүүхэд мэндэлсний дараа уг хүүхдийг угаах, нэр өгөх, өлгийд оруулах, онгон үсийг авах, хөлд оруулах, эмээл төхөөрөх (морь унуулах) гэх мэт цуврал зан үйлийг гэр бүл, төрөл төрөгсөд, ойр хавийн

айл хотлоор ёслон тэмдэглэдэг заншилтай. Эдгээрээс хүүхдийн сэвлэг үргээх зан үйл Монгол улсын хэмжээнд харьцангуй сайн хадгалагдаж байгаа гэж үзэж энэ сэдвийг сонгон авлаа. Гагцхүү өнөө цагт ямархуу байдлаар уламжлагдаж байгааг тодруулах нь чухал гэж үзээд хүн амын дийлэнхийг бүрдүүлдэг халх угсаатанд ажиглалт хийв.

Түүнчлэн сүүлийн үед хүүхдийн сэвлэг үргээх зан үйл болон ялангуяа иргэний найранд чухал байр суурьтай аман зохиолын төрөл, зүйлсийн байдлыг ажиглаж үнэлсэн судалгаа дутмаг байна. Хүүхдийн сэвлэг үргээх ёсны талаар Б.Сарангэрэлийн “Хүүхдийн даахь үргээх ёс” хэмээх ном [Сарангэрэл, 2016] хэвлэгдэн гарсан бөгөөд хүүхдийн үс даахийг зөв хөндөх тухай голлон өгүүлжээ. Үүнээс өмнө Х.Нямбуугийн “Өнөөгийн монгол ёс” [Нямбуу, 1976], Х.Сампилдэндэвийн “Малчин ардын зан үйлийн уламжлал” [Сампилдэндэв, 1985] зэрэг бүтээлд энэ талаар тусгайлан бичсэн хэсгүүд бий. Тэдгээрт тухайн цаг үеийн сэвлэг үргээх ёсыг танилцуулсны зэрэгцээ бэлгэ дэмбэрлийн үгс, ерөөлийг онцлон дурдсан байна. Энэ нь хүүхдийн үсний найрын гол утга нь хүүхдэд бэлэг сэлт өгөхөд бус харин сайн үгээр ирээдүйг нь уран цэцэн үгсээр зөгнөн хэлдгийг тэдгээр эрдэмтэд анзаарсан хэрэг. Бид ч энэхүү үндэслэлийг мөрдлөг болгон судлахын хамт хүүхдийн сэвлэг авах зан үйл, түүний ёслолд хадгалагдаж байгаа соёлын тэмдэгтүүдийг (код) тодорхойлох замаар,

1. Хүүхдийн сэвлэг үргээх ёслолын зан үйлийн аман чанар (нэршил, аман зохиолын зүйлс, дом, цээр)
2. Хүүхдийн сэвлэг үргээх ёслолын үйл явц, соёлын утга (сэвлэг үргээх, сэвлэг үргээх найр, найрын ёс) зэрэг хоёр чиглэлээр авч үзэх болно.

Түүнчлэн, бид өнөө цагийн халхчуудын хүүхдийн сэвлэг үргээх зан үйлийг биечилсэн ажиглалт судалгаандаа тулгуурлан баримтуудыг цуглуулах, харьцуулах аргаар бичсэн болно.

### 1.1. Хүүхдийн даахь авах ёслол дахь аман зохиолын зүйл (вербаль чанар)

Хүүхдийн онгон үсийг авах ёслолыг халхчууд сэвлэг үргээх, даахь авах, хүүхдийн

үс авах, мөн үс хөндөх гэж, ойрад монголчууд, өрвөө юм уу өрвөлөг хайчлах, үргээх, мөн зарим нутагт сэгсээ авах ч гэнэ<sup>1</sup>.

Зарим хүмүүс 1-2 настны үсийг сэвлэг, 3-дээс насны хүүхдийн үсийг даахь гэнэ гэсэн тайлбар байдаг нь энэхүү зан үйлийг нэрлэдэг нутаг нутгийн онцлог нэршилтэй холбоотой гэж үзэж болно. Мөн хүүхдийн унаган үсийг өөрөөр нэрлэсэн жишээ тууль, үлгэрт бий. Жишээ нь, “Наран хөвүүн хаан” хэмээх туульд,

Хонгор шар хонголцогоо

Хоёр тал руугаа хийссэн

Хоо шар хөвгүүн [Балдандорж, 2015. Х. 137], Хонголцог үст Хонгор улаан хүү... [Хан харангуй тууль, 2016. Х. 82, 85] гэх мэт.

Монголчууд хүүхдийн хэвлийд байх хугацааг нэг нас гэж тооцож түүнийг *хий нас* гэдэг. Энэхүү хий насыг оруулан эрэгтэй хүүхдийг сондгой тоотой нас буюу 3,5 насанд намар бугын дуунаар, эмэгтэй хүүхдийг тэгш тоотой нас буюу 2,4 насанд нь зуны эхэн сард хөхөө дуугарах цагт авдаг заншилтай. Энэ нь эрт цагийн уламжлалтай гэдгийг Монголын түүхэнд хамаарагдах дундад зууны сурвалж бичгүүд дэх сар бүрийн нэрээр баримжаалж болно. Тухайлбал, XV зууны “Хуа и июй” тольд, 3-р сарыг өвөөлжин, 4-р сарыг хөхөө, харин 8-р сарыг буга, 9-р сарыг хуц хэмээн нэрлэдэг байсан тухай мэдээ бий [Жуковская, 2002. С. 47] бөгөөд эрт үед энэ заншлыг баримталж хүүхдийн үс даахийг шинэчилдэг байсан бололтой. Дашрамд дурдахад өнөө цагийн монголчууд хүүхдийн сэвлэг үргээх өдрийг лам

<sup>1</sup> Монгол хэлний тайлбар тольд ДААХЬ гэдгийг 1. Ширэлдсэн үс хялгас, 2. Адгуус амьтны гуужих үс ноос, 3. Бага хүүхдийн сэвлэг (даахь авах-хүүхдийн нялхын үсийг анхлан авах, даахь гаргах-хүүхдийг үс гээгний дахирааг самнаж даахийг задлах, даахь үргээх-бага хүүхдийн онгон үсийг авах...) (<https://mongoltoli.mn/dictionary/detail/29134>) хэмээн, харин СЭВЛЭГ хэмээх үгийг 1. Үсний хүндэтгэл нэр, 2. Нялх хүүхдийн онгон үс, 3. Тав гээг, 4. Зарим ургамлын үндсэнд буй сахал мэт зүйл (<https://mongoltoli.mn/dictionary/detail/81271>) гэжээ. ӨРВӨЛӨГ гэх үгийг 1. Шувууны жижиг өд, чандар, 2. Тахианы толгойд ургасан хэсэг үс өд, толгойн цэцэг; 3. Буурын толгойн ар дахь сэгсгэр үс; 4. Хүүхдийн үсний хүндэтгэл, 5. Хулс, зэгс зэрэг ургамлын сагсар түрүү (<https://mongoltoli.mn/dictionary/detail/72749>) хэмээн тус тус тайлбарлажээ. ӨРВӨӨ гэдэг нь өрвөлөг гэх үгтэй төстэй нялх хүүхдийн унаган үсийг нэрлэсэн нутгийн аялгууны шинжтэй үг юм

зурхайчаас асуудаг бөгөөд хүний үсээ засуулах, авахуулах өдрөөс тусдаа ойлголт юм.

Монгол ардын үлгэрт хүүхдийн сэвлэг үргээх цагийг сонгох тухай өгүүлсэн нь бий. Тухайлбал, “Хүүхдийн даахь үргээлцсэн нь” хэмээх бадарчны үлгэрт “Баадай олон шөнө хээр хонож ядарч явтал арайхийн нэг айл тааралдаж... айлд ортол, эр эм хоёр их л олзуурхан “Маргааш манайх хүүгийнхээ даахийг үргээх юм аа. Та манайд хонож тус болооч... Энэ зүүн голд хонь жилтэй нэг хүн байгаа юм. Түүнийг залж ирээд хүүгийнхээ үсэнд эхэлж хайч хүргүүлэх юм” гэсэнд бадарчин Баадай “Би ч гэсэн яг 49-нийхээ хонин жил дээр яваа хүн дээ” гэхэд айлынхан “Тэгвэл бүр сайн байна. Та манайд хоноод маргааш тэр хүний оронд хүүгийн минь үсэнд хайч хүргэж ерөөл тавьж хайрла” гэсэнд Баадай дуртайяа зөвшөөрч тэднийд хонохоор болжээ...Маргааш өглөө нь өнөөх айлын эзэгтэй мах чанаж тавгийн идээ засаад, “Одоо цаг нь боллоо, ёслолоо эхлээ” гэсэнд бадарчин худал хэлсэндээ санаа зовж “би бодоод байсан чинь танай хүүтэй харш жилтэй” хэмээгээд үсний найрны хувиа (бэлэг, хишиг) хэмээн тавагтай махнаас авч өвөртлөөд явсан тухай өгүүлдэг [Сүрьяа, 2018. Х. 22-123].

Энэхүү үлгэрт хүүхдийн үсийг анх хайчлах хүн нь тухайн хүүхэдтэй ивээл жилтэй байх, идээ будаа засаж бэлтгэдэг, хүүхдэд зориулж ламаар ном уншуулдаг зэргийг мэдэж болохоор байна.

Монгол аман зохиолын том төрөл баатарлаг туульд хүүхдийн даахь үсийг хөндөх зан үйлийн тухай олонтаа өгүүлдэг. “Хөхөө дэглэн” хэмээх туульд гурван настай Мэхлээлэй хүү адуугаа цуглуулж явтал нэг л сайн эрийн дуу зүүн талын чихээр ороод баруун талын чихээр гараад явчихаар нь хаан аавдаа очиж,

“Эр бие өслөө

Эзэн төрд үйлчлээ

Хатуу зориг барья

Хаан төрд үйлчлээ” гэсэнд хаан аав нь “Толгойн чинь үсэнд тонгорог ч

хүрээгүй билээ/ Тун ч бие чинь эр болоогүй байна” хэмээн татгалздаг [Халх тууль, 2013. Х. 76] бол, “Хөх халзан морьтой Хөхөлдэй мэргэн хаан” туульд баатар хүү төрөөд хөлд

сайн ороогүй байхдаа дайснаа дарж дархан цолоо олж, бугаа дарж бурхан цолоо ольё хэмээхэд нас чинь бага, цус чинь шингэн байна энэ жилдээ өнж гээд,

Тойн болсон толгойд чинь

Хүйтэн иртэй мэс хүргээгүй байна.

Төрсөн сайхан биед чинь

Тэр гэдэг алдар нэрийг өгөөгүй байна [Дөрвөд аман зохиолын

чуулган, 2017. Х. 230-231] гээд “Хар чулуур хагартал хэлдэг, Харз усыг буцалтал хэлдэг хайрт хар түшмэл”-ээсээ асуухад түшмэл нь “тойн болсон толгойд нь хүйтэн иртэй мэсний үзүүр хүргээд төрсөн биед нь нэр цолыг нь өгөөд аль хурдан алс хол явуулбал дайснаа дарах л байх аа, дархан цолоо болох ч байх” гэнэ. Тэгээд найр жаргал хийж байгаа тухай өгүүлжээ.

Хүүхдийн сэвлэгний найрт хэлдэг “Даахины ерөөл”-хэмээх тусгай ерөөлд ч уг ёслолын үйл явц, дэс дарааллыг өгүүлсэн мэт байдаг онцлогтой. Жишээлбэл,

...Эрхэм хайрт танайх болбол

Зургаан үндсэн хуанлид үзээд

Зуугаас ирсэн зурхайчид үзүүлээд хэмээн өлзий хишиг бүрдсэн өдрийг сонгон

даахь үргээх гэж байгааг дурдаад ивээл жилтэй хүнийг эхлэн залж олон түмнээ урин ирүүлээд ган цагаан хайч, гавшгай цагаан тонгоргийг бэлдэж,

Ган хошуутай алтан бариултай хайчаа

Гар мутар бүхийдээ дамжуулан үргээж ...

“Баруун талын шанаанаас нь

Эхэлж үргээхэд

Бадам лянхуа цэцэг дэлгэрч байгаа мэт

Зүүн талын шанаанаас нь авч үргээхэд

Зүйл бүрийн эрдэм цацарч байгаа мэт

Орой дээрээс нь авч үргээхэд

Ой билэг нь хурцдаж

Оюун ухаан нь нэмэгдэж байгаа мэт

Ар шилэн дээрээс нь авч үргээхэд

Агуу их хүчин төгөлдөр

Атаа хүчин нэмэгдэж байгаа мэт” гэхчлэн хүүхдийн толгойн аль хэсгийн

үсийг ямар дэс дарааллаар авахыг өгүүлээд сайн сайхныг ерөөн хүсэж байгаагаар өндөрлөдөг [Монгол ардын зан үйлийн аман зохиол, 1987. Х. 276-277]. Одоо энэ заншил үндсэндээ хадгалагдаж, сэргэж байна.

2020 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монголын Үндэсний Олоннийтийн телевизийн хамтран хэрэгжүүлсэн “Билиг бэлгийн дээж” нэвтрүүлэгт Улсын тэргүүн зэргийн ерөөлч Сугирын Мөнхжаргалын зохиосон “Дахины ерөөл”-ийг түүний ач Өмнөговь аймгийн 5-р сургуулийн 5Д ангийн сурагч Д.Мөнгөнбаатар хэлсэн юм. Уг ерөөлд ардын ерөөлд байдаг мөрүүдээс гадна зохиогчийн гэх мөрүүд байна. Тухайлбал,

...Настан буурлууд, найз нөхөд  
Найрлан цэнгэхдээ  
Нанчид сархадыг уулгүй  
Наана цаана бололгүй хэмээн сануулсан,  
Үйлс бүтээл дэлгэрүүлсэн  
Үр хүүхдээ хайрласан  
Хүүгийн сэтгэлийг татсан  
Хүн бүр бэлэгтэй

Хүндэлж өхөөрдөөд гоёхон байна хэмээн сайшаасан өнгө аяс ч цухалзана. Хүүхдийн сэвлэгний найрт хэлдэг ерөөл хадгалагдсан боловч халхчуудын ерөөл давамгай түгсэн учраас нэг хэв загварт шилжих байдал ажиглагдаж байна.

Хүүхдийн дахины найрт ерөөл, бэлгэ дэмбэрлийн үгс хэлэхээс гадна уртын дуу дуулдаг. Уртын дууны хувьд ая, үгийн утга санааны хувьд тодорхой журам мөрдөгдөж байв. Гэхдээ энэ журам ёс хэсэг мартагдаж байгаад сэргэх хандлагатай болсон бөгөөд хөдөө орон нутагт илүү язгуур чанартай байгаа бол хотод ямар нэг ресторан, хүүхдийн тоглоомын төв, гэрийг барууны хүүхдийн ойн баяр хэрэглэдэг бөмбөлөг, элдэв дүрс, тууз тэргүүтнээр засаж тэнд ерөөлч, уртын дуучигүй, харин хүүхдэд зориулсан зохиолын дуу, бүжигтэйгээр ёслон тэмдэглэдэг хандлага ажиглагдаж байна.

## 1.2. Судлагдахууны үйл явц, түүн дэх нэгэн биет зүйлийн тухай

Дөрвөдийн “Хашинцагаан хаан” гэдэг туульд хүүхдийн сэвлэг үргээх ёсны талаар нэлээд дэлгэрэнгүй дүрсэлсэн байдаг. Уг туульд, Хаан аав, хатан дүнгээ хоёрын нэг настай нялх үстэй хөвүүн нь хөхнөөсөө гараагүй байхдаа “дайснаа дарж дархан цолоо олно” гээд явах гэсэнд хаан аав нь татгалзаж “Тойн болсон толгойд чинь

хүйтэн иртэй мэс хүрээгүй байна” хэмээдэг. Тэгээд нялх балчир хөвгүүний толгойд “гар хүрэх” хүнийг адуучийн Аг сахал өвгөний азай буурал самганаар хүргэх болдог. “Ган иртэй хүйтэн мэсий нь аваад,

Алд шар хив (хадаг) зүүгээд  
Далан хүн дамжлаад даашгүй  
Далай цоохор хундганд нь  
Ариун цагаан сүүгээ хийгээд  
Ах дүү  
Арван гурван хиануудын  
Ахмад цагаан хиа нь тэврээд  
Зүүн хойморын эхэнд суурьшсан  
Адуучин аг сахал өвгөний  
Азай буурал эмгэний өвөр дээр тавиад  
Эмгэн буурал минь энэ хүүгийн толгойд  
Хүйтэн мэс хүргээд өгөөч гэж  
Хив шар хадгаа дэлгээд барив гэнэ”

Эмгэн хүүг баруун өвдөг дээрээ тавиад баруун хацрыг нь таалаад баруун араанд нь бал бурам хашин зажлуулаад, зүүн өвдөг дээрээ суулгаж зүүн хацрыг нь таалаад, зүсэн зүйлийн чихэр бурам зүүн араанд нь хашин зажлуулаад “хөвүүн чамд таван цагаанаараа бэлэг барья” гээд таван цагаан морь, таван цагаан хонь, таван цагаан үхэр, таван цагаан тэмээ, таван цагаан ямаа өгөхөөр амлана. Мөн “Тангад таван бүстэй, тавин мянган Хөхий нугийн эзэн болоод таван живаа албат иргэнээ захирсан Холын хортныг даран төрсөн эрийн сайн баатар эр болтугай!” гээд аман ерөөл тавьж баруун талын шанаанаас нь нэг атга үс хайчлан авч байгааг өгүүлнэ. Энэчлэн хаан аав нь хүүгийнхээ баруун, зүүн хацрыг үнсэж чихэр үзэм өгч “Хүү минь тавиан хөх нутгийг минь эзлээд тавин живаа албат иргэдийг минь захирсан Хашин зандан ширээн дээр минь хаан болж суугаад харийн хортон дайсныг даран төрсөн Эрийн сайн Хайр хар гэдэг нэртэй баатар болоод урт наслаад удаан жаргаж явахын билэг ерөөл орших болтугай!” гээд баруун талын шанаанаас нь бараг нэг атга үс хайчилж авсан, дараа нь хатан ээж нь удаад нь Адуучийн Аг сахал өвгөн бэлэг ерөөлөө тавьж үүрийн цолмонгоос үүссэн үрээ хүрэн морь бэлэглэж туг үс хайчилна.

Энэчлэн хааны түмэн живаа албат иргэд цөм тэр хөвүүний үснээс хайчилж аман ерөөлөө тавиад, “түүнээс үлдсэн үсээр нь хөх

л тэвэг” тавьсан тухай өгүүлжээ [Дөрвөд аман зохиолын чуулган, 2017. Х. 190-191]. Монгол тууль дахь хүүхдийн унаган үсийг авах ёслолыг ийнхүү дүрсэлсэн нь өнөө цагийн хүүхдийн үсний найртай үндсэндээ төстэй байдаг. Түүгээр үл барам тувачуудтай ч үндсэндээ адил байгааг судлаачдын бүтээлээс харж болно [Кара-оол, 2013. С. 34-36].

Бид халхчуудын сэвлэг үргээх найрны өнөө цагийн байдлыг ажиглахаар 2022 оны 5 сарын 3-ны өдөр Өвөрхангай аймгийн Уянга сумын Шуранга багийн Нарийны гол гэдэг газар зусаж буй Сүхбатын Эрдэнэсүвд, Даваадоржийн Баттогтох нарын ууган хүү, 5 настай Батчулууны даахины найрт оролцсон юм.

Уг найр өглөө, үүрээр 5 цагт эхэлнэ гэсэн тул бид ч сумын төвөөс эртлэн хөдөлж очиход хот айлынхан хэдийнээ бэлтгэлээ хангасан, гэрт хүмүүс цугларсан байлаа. Зүүн талаар эмэгтэйчүүд, баруун талаар эрчүүд сууцгаасан, ирсэн зочдод цай өгч, идээ амсуулав. Гэрийн баруун хойт талд өндөр сандлыг улаан өнгийн бөсөөр бүтээн түүн дээр шинэ дээлтэй хүүг суулгасан байв. Эхлээд лам ерөөл уншив. Нэлээд хугацаанд уншсаны дараа Э.Батчулуун хүүгийн нагац ах ивээл жилтэй гээд сэвлэвт нь эхлээд модон хутгаар хүрээд дараа нь баруун шанаанаас нь багц үс авч хадагны нэг үзүүрт зангидан боов. Дараа нь гэрийн зүүн хойно суусан ерөөлч Зузааны Даансүрэнгийн Амгалан (халх, эрэгтэй. 1958 онд төрсөн) даахины ерөөлийг хэлэхэд найрчид “тэр ерөөл бат сайхан орших болтугай!” хэмээн дэмжив. Дараа нь хүүгийн даахинаас аав, ээж, ах эгч нар нь төрөл төрөгсөд дэс дараалан хайчилж, бэлэг өгч байлаа. Бэлэг нь ихэвчлэн хүүхдийн тоглоом, хувцас, төгрөг зэрэг байв. Харин хүүгийн эмээ Цэдэннамжилын Эрдэнэням “Үлэмжийн чанар”, “Хүрэн толгойн сүүдэр” уртын дууг дуулав. Уртын дууг сайн дуулсан боловч утга агуулга нь бүрэн нийцтэй гэх аргагүй байсан болно. Гэхдээ сэтгэлээсээ дуулж байсан гэдэг нь эргэлзээгүй. Бид хүүд бэлэг өгч бэлгэ дэмбэрлийн үг хэлсэн.

Эцэст нь хүүхдийн үсийг нагац ах нь үсний машинаар машиндаж аваад шар тосоор тослож шинэ малгай өмсгөхөд хүү найзуудтайгаа шинэ

тоглоомоор тоглохоор гарч явав. Томчууд харин архи дарс ууцгаасангүй, лам найрт зориулан чанасан хонины чанасан маханд эхлээд хүрч найрчдад хишиг түгээв. Махыг жижиглэн хэрчиж тавган дээр тавиад тойруулахад хүмүүс түүнээс авч амсаж байв.

Хамгийн сонирхолтой нь, хүүгийн нэг ах, хижээл насны хүн хонины уураг сүүлэнд шаант чөмгийг шагайтай хэсгээр нь хатгаж түүнээ бурхан дээрээ залав. Уг хишгийг харахад хонины сүүл хэсэг нь дороо шаант чөмөг нь дээрээ завилгаатай хүн шиг харагдав. Юуны учир ийнхүү тавьсныг асуухад манай ёс ийм. Чухам ямар учиртай ингэж тавьдаг нарийн учрыг мэдэхгүй, хуриманд ч ингэж тавьдаг гэв.

Хүүхдийн сэвлэг авах, хуримын ёслолд уураг сүүл, шаант чөмгийг юуны учир ингэж тахил болгон тавьдгийг нэлээд хүмүүсээс лавлахад төв болон говийн халхчууд хурим найр, хүүхдийн үсний найранд бурхан тахилдаа ингэж залдаг, цагаан сарын баяраар бурхан тахилдаа, зарим тахилгын үед овооны тахилд ихэвчлэн хонины толгойг тавьдаг гэхээс учрыг нарийн хэлж мэдэхгүй байсан юм. Ямартай ч уураг сүүл, шаант чөмгийг наадам юм уу, тахилгад бус харин хурим, хүүхдийн найранд уураг сүүлтэй хамтатган тавьдаг нь тодорхой болж байна.

Шагайт чөмгийг хуримын зан үйлд хэрэглэдэг өөр ёстой холбон үзэж болно. Жишээ нь, хурим хийхэд бэр, хүргэн хоёрыг мандах нарны зүг хандуулан цагаан эсгий дээр суулган эрэгтэй бүдүүн хэсгээс, эмэгтэй шагайт талаас нь атгаад наранд гурвантаа мөргөдөг байснаас “шар наранд мөргөж, шагайд чөмөг атгах” гэдэг үг гарчээ. Энэ бол Хүннүгийн үеэс үүсэлтэй, нар эрхэмлэх заншлын тусгалаас гадна шаант чөмгийг эрхэмлэх ёсны илхэл юм.

Монголчууд хуримын үед бэр буулгах ёслолын үед “чөмөг гүйлгэх”, “шагайт чөмөг наадуулах” наадаан хийдэг бөгөөд бэр, хүргэний талын эрчүүд морьтойгоо хоёр тал болон зогсоно. Тэдний дунд нь хэн нэг хүн шагайтай хэсэгт хадаг уясан шагайт чөмгийг дээш шидэн хаяж өгнө. Баяд, дөрвөдөд чөмгийг авсан талынхаа өөрийн талын хүмүүст дамжуулдаггүй, харин халхчууд өөр хоорондоо шидэж дамжуулдаг, нөгөө тал энэ үед замаас нь

булаан авахыг хичээдэг. Чөмгийг барьсан хүн толгой дээрээ чөмгийг хадгийг намируулан давхиж өөрийн омог, талынхны хурд хүч, авхаалж самбаа, эрэмгий зоригоо гайхуулан нааддаг уламжлал бий.

Гэр бүлд анхны хүүхэд төрөхөд шаант чөмөг чанаж шөл гаргаад уг шөлийг бүлээсгэн хүүхдийг угааж, шагайг нь хүүхэд төрсний бэлгэдэл, анхны тоглоом болгон хадгалдаг. Тиймээс урианхай эмэгтэйн бүснээс унжих нарийн сур юм уу, хүүхдийн модон өлгийн дээгүүр татсан нарийн суранд шагайг хавчуулан зангиддаг. Хүн түүнийг хараад тухайн эмэгтэй, айл хэдэн хүүхэдтэй гэдгийг мэддэг байжээ.

Халхчууд мах чанаад хүүхдэд бараан мах буюу өөхгүй мах өгөхийг чухалчилж богтос, шаантны махыг идүүлэхийг эрмэлздэг. Энэ тухай эмэгтэйчүүдээс лавлахад батлан хэлж байгаа бөгөөд булчин мах нь хүүхдийн шүдний бэхжилтэнд сайн, шимтэй хоол болдог, бөхчүүд барилдах бэлтгэлийн үедээ чухамхүү булчин мах чанаж иддэг гэх мэт мэдээг өгүүлэв.

Чухамхүү хүүхдийн даахины найрт уураг сүүл, шаант чөмгийг хишиг болгон тахил болгон тавьж байгаа нь магадгүй эрт үеийн “ам барих ач” гэдэг домогзүйн сэтгэлгээний улбаа байж болох юм. Уг домгийн ёсоор бол өвөг эцэг нь өөр ертөнцөд одохын өмнө үр ачаа тойруулан суулгаж үг сургаалиа айлдсаны дараа ач нь өвөг эцгийн аманд уураг сүүл хийж араас нь шаант чөмгийн шагайтай, нарийн хэсгээр араас нь түлхэх байдлаар амьсгалыг нь бүтүүлэн “холын аян”-д нь мордуулдаг заншил байсан гэдэг [Ал-таа, 2020. Р. 46-55]. Энэ зан үйлтэй хамаарах домог, үлгэрийн олон жишээ, археологийн баримтууд бий. Жишээ нь, хүүхдийн оршуулга, булшинд (Өвөрхангай аймгийн Барзан уулын

булш) шагай дагалдуулан оршуулдаг тухай археологичид олонтоо тэмдэглэжээ.

Халхчууд дээрхээс өөр үйлд бэлгэдлийн чанараар хэрэглэдэг өргөн дэлгэрсэн нэгэн ёс бол эрчүүд анд мордохын өмнө ганзагыг тахих ёсон хэмээн зүүн хойт ганзганд нь шагайт чөмөг, зүүн урд нь уураг сүүл (баруун урд нь дөрвөн өндөр, баруун хойно нь хошног) ганзаглаж 4 зүгт хүж зул сан тавиад “Ганзагын сан” уншдаг байжээ (Ганзагын сан оршвой. Гар бичмэл. Г.Ням-Очирын хувийн номын санд буй).

Монгол туульд гардагчлан эрэгтэй хүүхэд 3 нас хүрээд холын аянд мордож, хортон дайсантай тулалдаж нэр алдараа анхлан цуурайтуулсан тухай өгүүлдэг билээ. Тиймээс “Даахин дор унага, дахан дор эр” гэдэг үг буй. Судлаачид хүүхдийн даахь үсийг нь авсны дараа хүүхэд шинэ төрхтэй болж, түүний нэгэн шинэ үе эхэлж байгаа чухал ёслол гэж үздэг. Үнэндээ буриадад охидыг багад нь сэвлэгийг авсны дараа үсийг 6 салаа сүлжиж, 13-15 насанд нь гээг тавьж, чимэг зүүлт (сааж) зүүж, гэр бүл болмогц үсийг хоёр салаа сүлжин эхнэр үсний засалтаар самнадаг нь нэг ёсондоо насны үе шаттай холбоотой гэж үзэж болохоор байна.

Хүүхэд гэр бүлийнхээ бүрэн эрхт гишүүн нь болсон гэдгийг олон хүнээр “гэрчлүүлэн” ёслол үйлдэж буй сэвлэг үргээх ёслолыг нэг ёсны дом гэж үздэг. Тиймээс айлын энхрий хүүхдийн сэвлэгийг арай хожуу буюу 8, 9 насанд нь авдаг ёс бий. Түүнчлэн хүүхдийн даахины найрт уригдсан хүн ихээхэн бэлэгшээх бөгөөд хүүхдийн үсэнд хүрсэн бол хариуд нь заавал бэлэг өгч “мялаана”. Буриадууд сэвлэг авах ёслолыг “милаан” буюу мялаалга гэдэг. Тувачууд хүүхэд “...анхны, нялхын үсээ авахуулж байгаа нь хүүхэд өөр ертөнцөөсөө сая тусгаарлагдаж жирийн хүмүүсийн адил болж байгаа хэрэг... амьд хүмүүс л гөрмөл гээгтэй байдаг” [дам эш. Курбаковский, 2001. С. 57].

Өөр нэг ойлгомжтой тайлбар бол монголчууд хүний үс, ялангуяа толгой, тэргүүнийг ихэд эрхэмлэдэг учир хүүхдийн сэвлэг, даахинд сайн өдөр, ивээлтэй хүн нь хүрдэг, тусгай ёслол хийдэг, сэвлэг, гээг үсийг нандигнан хайрладаг



Монголчуудын хувьд, хүүхдийн сэвлэг үргээх зан үйл нь олон талтай, гүн утга агуулгатай ёслол юм.



заншилтай юм. Бид 2022 онд Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд очиж 91 настай, Улаалзай хүүдүүд Бадамын Лхамсүрэн гуайтай уулзаж хүүхдийн сэвлэг, даахины тухай асуухад охин байхдаа гэрээсээ авч ирсэн дэрэн дотроо хүүхдүүдийнхээ сэвлэгийг нандигнан боож хадгалсан байснаа үзүүлээд, хэрэв хүүхэд нь багадаа өвдвөл шатааж утдаг. Хэрэгтэй “зүйл” байгаа юм. Ер нь даахийг нь бүгдийг хадгалдаггүй, хэсгийг аваад, үлдсэнийг нь шатаачихна. Үнсийг нь хамаагүй хаядаггүй гэсэн юм.

### Дүгнэлт

Халхчуудаас авсан санал асуулын дийлэнх нь хүүхдийн сэвлэг үрээх заншлын гол утга бол энэ ёслолоос хойш хүүхдийн амь нас бататжилаа гэсэн утгатай гэдэгт санал нийлж байлаа. Үүнийг нарийвчилбал, хүүхэд ээжээсээ эхлээд хүй, эхис зэргээс таслагдах үед тодорхой ёслолууд хийдэгтэй (хүй таслах, эрхис оршоох гэх мэт) нэгэн адил эхээс авч гарсан үсийг нь авах үед нэгэн адил ёслол хийж байгаа цуврал ёслолын нэг гэж болно.

Хүүхдийн унаган үсийг авах зан үйл монгол, буриад, халимаг, өвөрмонгол, тэрчлэн тувачуудад бага зэргийн ялгаа байх боловч нийтлэг шинжтэй, 2-3 нас хүртэл хүүхдийн үсийг нь хөнддөггүйн дээр сондгой тоог эх-арга тоо гэж эрэгтэй хүүхдэд, тэгш тоог билиг гэж эмэгтэй хүүхдэд хамааруулан үсийг нь нас болон улирлаар ялгаатай хөндөж байна. Энэ нь сондгой тоог арга, тэгш тоог билэг гэж үзэн эрэгтэй, эмэгтэйд хамааруулдаг монголчуудын уламжлалт ойлголттой холбоотой юм.

Хүүхдийн унаган үс зөөлөн, нарийн ширхэгтэй учир хонгор даахь, сэвлэг гэх мэт нэршилтэй байгаа бөгөөд түүнийг хусах зэргээр авч дахин ургуулснаар үс илүү бат бөх болдог гэдэгтэй хүмүүсийн санал нэг байна. Тиймээс монгол орны хатуу ширүүн байгалийн нөхцөлд нийцүүлэн, хүний үсийг шинэчилж байгаа үйл явц гэж болно. Бидний ажигласан айлын хүүхдийн толгойд шар тос түрхэж байгаагийн учрыг асуухад “шар тосоор мөнгөн толгойг нь (үсийг нь хуссан хүүхдийн толгойг өхөөрдөж ийн нэрлэв) мялааж байгаагаас гадна шинээр ургах үс нь илүү өтгөн бат бөх болдог” гэж тайлбарласан юм.

Хүүхдийн сэвлэг үргээх ёсны өөр нэг утга бол домын үйл юм. *Нэгд*, хүн, хүүхдийн тэргүүнийг ихэд хүндэтгэдэг монгол заншлаар хүний толгойд мэс хүргэнэ гэдэг онцгой зүйл бөгөөд багад нь энэхүү домьг хийснээр тухайн хүүхэд цаашид хутга мэсний аюулаас зайлнэ гэж үздэг. Нэлээд хүн багадаа даахиа хөндүүлээгүйгээс том болсон хойноо бие өвдөх, гай зовлон тохиолдоод байсан учраас ламд очиж энэ ёслолыг нөхөн үйлдүүлээд зүгээр болсон тухай хуучилж байлаа. Үүнийг “зүсээ өөрчлөх”, “үсээ хусуулах дом” хийлгэсэн гэж ярьдаг. *Хоёрт*, хүүхдийн сэвлэг буюу нялхын үсийг авахгүй бол хүүхэд ууртай, ухаан муутай болно гээд ирээдүйн амьдрал нь сайн сайхан байгаасай хэмээн энэхүү ёслолыг үйлддэг ажээ. Эдгээр нь монголчуудын үс, хялгасыг эрхэмлэх, тэдгээртэй холбоотой цээрийн ёстой холбогдож байна.

Хүүхдийн сэвлэг үргээх ёслол буюу найр нь өвөрмөц дэгээр хийгддэг бөгөөд найрын эзэн нь хүүхэд байж, хүндтэй байрыг эзлүүлнэ. Энэ найрт цагаалга, уураг сүүл, шаант чөмөг, хүүхдийг мялаах бэлэг зэрэг онцгой элементүүд бий. Хүүхдийн сэвлэгээс хайчлах хүн бүхэн цагаалгыг заавал амсдаг (зарим нутагт ламаар ном уншуулах, арц хүжээр ариулах г.м.) нь хүүхдийг сэвтээхгүй хэмээх өөрийгөө ариулж буй цээрийн ёс юм. Харин шаант чөмөг, уураг сүүл бол монголчуудын нэн эрт үеэс улбаатай, тэдний ахуй амьдралын түүхэн дэх соёлын чухал баримт болж байна.

Хүүхдийн сэвлэгний найрт ерөөлч хэмээх тусгай хүнийг урьж урт ерөөл хэлүүлэн, хүн бүхэн аман ерөөл хэлж, ургын дуу дуулдаг ёс социалст агуулагатай баяр гэдэг хэмжүүрээр нэг хэсэг тасарч байгаад хот суурин газар дахин дэлгэрч байна. Харин хөдөө орон нутгийнхан энэ уламжлалыг хадгалаж ирсэн гэж үзэхээр юм. Өөрөөр хэлбэл зан үйлийн аман зохиол нь ардын аман яруу найргийн эртний төрөл болж монголчуудын зан заншил, баяр ёслолын салшгүй хэсэг болж түүний учир утгыг нэмэн баяжуулдаг чанарыг хөдөө орон нутаг, түүний дотор малчид уламжлалыг залгагчийн үүрэг гүйцэтгэж байна.

## НОМ ЗҮЙ

Alimaa, 2020: *Alimaa A.* Some connections between Ethnography and Folklore. Studies on Cultures along the Silk Roads. Vol. 2. Institute of Ethnology, Reserch Centre for the Humanities, Institute of Excellent of the Hungarian Academy of Sciences; Institute of Ethnic Literature, Chinese Academy of Social Sciences. Hungary- Budapest., 2020. P. 46-55

Балдандорж, 2015: *Наран хөвүүн хаан.* Туулийг хайлж бичигт буулгасан А. Балдандорж. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2015. 200 х.

Naran khövüün khaan. Tuuliig khailj bichigt buulgasan A. Baldandorj [Naran Khovuun Khaan. The epic found and written down by A. Baldandorj]. Ulaanbaatar: Soyombo printing, 2015. 200 p.

Дөрвөд аман зохиолын чуулган, 2017: *Дөрвөд аман зохиолын чуулган.* Эмхэтгэсэн Б.Катуу. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2017. 563 х.

Dörvöd aман zokhiolyn chuulgan. Emkhetgesen B. Katuu [Miscellanea of the oral literature of dorvod people. Compiled by B. Katuu]. Ulaanbaatar: Soyombo printing, 2017. 563 p.

Жуковская, 2002: *Жуковская Н.Л.* Кочевники монголии. Культура Традиции Символика. Учебное пособие. М.: Издательская фирма «Восточная литература» РАН, 2002. 247 с.

Zhukovskaia N.L. Kochevniki mongolii. Kul'tura Traditsii Simvolika. Uchebnoe posobie [Mongolian nomads. Culture Traditions Symbols. Tutorial]. M.: Publishing company "Eastern Literature" RAS, 2002. 247 p.

Кара-оол, 2013: *Кара-оол Ч.А.* Обряд первой стрижки волос в традиционной культуре тывинцев. Исторические науки. Вестник Череповецкого государственного университета. 2013. No. 4. Т. 3. С. 34-36

Kara-ool Ch.A. Obriad pervoi strizhki volos v traditsionnoi kul'ture tyvintsev [The rite of the first haircut in the traditional culture of the Tuvinians]. Istoricheskie nauki. Vestnik Cherepovetskogo gosudarstvennogo universiteta. 2013. No.4. T 3. S. 34-36.

Курбатовский, 2001: *Курбатовский Г.Н.* Тывинцы в своем фольклоре: историка-этнографические аспекты тывинского фольклора. Кызыл: Тувинское книжное издательство, 2001. 462 с.

Kurbatovskii G.N. Tyvintsy v svoem fol'klоре: istorika-etnograficheskie aspekty tyvinskogo fol'klora [Tuvinians in their folklore: Historical-ethnographic aspects of Tuvinian folklore]. Kyzyl: Tuva book publishing house, 2001. 462 p.

Монгол ардын зан үйлийн аман зохиол, 1987: *Монгол ардын зан үйлийн аман зохиол.* Эмхэтгэж хэвлэлд бэлтгэж, удиртгал, тайлбар сэлт үйлдсэн Х.Сампилдэндэв. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1987. 342 х.

Mongol ardyn зан үйлийн аман zokhiol. Emkhetgej khevleld beltgej, udirtgal, tailbar selt üildsen Kh.Sampildendev [Mongolian ritual folklore. Intro., comp., comm., ed, by H. Sampildendev]. Ulaanbaatar: State Publishing House, 1987. 342 p.

Нямбуу, 1976: *Нямбуу Х.* Өнөөгийн монгол ёс. Улаанбаатар, 1976. 237 х.

Nyambuу Kh. Öнөөгийн mongol yos [Actual Mongolian traditions]. Ulaanbaatar, 1976. 237 p.

Сампилдэндэв, 1985: *Сампилдэндэв Х.* Малчин ардын зан үйлийн уламжлал. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. 1985. 342 х.

Sampildendev Kh. Malchin ardyn зан үйлийн ulamjla [Ritual traditions of herdsmen]. Ulaanbaatar: State Publishing House, 1985. 342 p.

Сарангэрэл, 2016: *Сарангэрэл Б.* Хүүхдийн даахь үргээх ёс. Улаанбаатар, 2016. 60 х.

Sarangerel B. Khüükhdiin daakhi ürgeekh yos [Traditional parenting]. Ulaanbaatar, 2016. 60 p.

Сүрьяа, 2018: *Сүрьяа Д.* Бадарчингийн инээдэмт паян. “Бадарчин Баадайн Инээдэмт Паян (Монгол ардын шог үлгэр) Улаанбаатар: “ДАС ихэр” сан, “Супержобс ХХК” хэвлэлийн газар, 2018. 153 х.

Sүriyaa D. Badarchingiin ineedemt payan. “Badarchin Baadain Ineedemt Payan (Mongol ardyn shog үlger) [Badarchin’s funny payan. “Badarchin Baadain Ineedemt Payan (Mongolian Folk Tale)] Ulaanbaatar: “DAS Iher” Foundation, “Superjobs LLC” Publishing House, 2018. 153 p.

Хан харангуй тууль, 2016: *Хан харангуй тууль.* Удиртгал бичиж, үгсийн тайлбар хийн орчин цагийн монгол хэлээр хөрвүүлж хэвлэлд бэлтгэсэн Б.Түвшинтөгс. Улаанбаатар-Санкт Петербург: Соёмбо принтинг, 2016. 209 х.

Khan kharangui tuuli. Udirtgal bichij, үgsiin tailbar khiin orchin tsagiin mongol kheleer khörvүүлj khevleld beltgesen B.Tүvshintögs [Khan kharangui tuuli. Intr., comm., transl. into modern Mongolian and ed by B. Tuvshintögs]. Ulaanbaatar –Saint-Petersburg: Soyombo printing, 2016. 209 p.

Халх тууль, 2013: *Халх тууль.* Эмхэтгэсэн А. Алимаа. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2013. 408 х.

Khalkh tuuli. Emkhetgesen A. Alimaa [Khalkh epic. Compiled by A. Alimaa]. Ulaanbaatar: Soyombo printing, 2013. 408 p.

*Сайтууд*

<https://mongoltoli.mn/dictionary>  
[https://www.youtube.com/watch?v=vt2iqFzUcPk&ab\\_channel=MongolianNationalBroadcaster](https://www.youtube.com/watch?v=vt2iqFzUcPk&ab_channel=MongolianNationalBroadcaster).

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монголын Үндэсний Олон нийтийн телевиз. “Билиг бэлгийн дээж” нэвтрүүлэг. С.Мөнхжаргал “Даахины ерөөл”. Өмнөговь аймгийн 5-р сургуулийн 5Д ангийн сурагч Д.Мөнгөнбаатар

[https://www.facebook.com/permalink.php?story\\_fbid=pfbid048Aaq6WfRhpBkSD8YCPvg56bSTkYQPnhCdGoP4bs4fV6XxDd9w3cLRKGayKxjGEol&id=100008588716629](https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid048Aaq6WfRhpBkSD8YCPvg56bSTkYQPnhCdGoP4bs4fV6XxDd9w3cLRKGayKxjGEol&id=100008588716629)

Ганзагын сан оршвой. Гар бичмэл. Г.Ням-Очир.

*Уулзаж мэдээлэл өгсөн голлох хүмүүс*  
Зузаан овогтой Даваасүрэнгийн Амгалан (Эрэгтэй. Халх. 1958.05.19-нд төрсөн). Өвөрхангай аймгийн Уянга сум. Нарийны гол. 2022.05.03-нд уулзав.

Сүхбатын Эрдэнэсүвд, Даваадоржийн Баттогтох нарын ууган хүү, 5 настай Батчулууны даахины найр Улаалзай хүгдүүд Бадамын Лхамсүрэн (Эмэгтэй. 91 настай, буриад). 2022 он, Дорнод аймгийн Цагаан-Овоо сум. 2022.01.09-нд уулзав.

## КУЛЬТУРНОЕ ЗНАЧЕНИЕ ЦЕРЕМОНИИ СТРИЖКИ ВОЛОС ДЕТЕЙ-ХАЛХОВ В МОНГОЛИИ В НАСТОЯЩЕЕ ВРЕМЯ

Аюушжав АЛИМАА

Институт языка и литературы Монгольской академии наук

В статье на основе архивных и новых полевых материалов рассматривается ритуал стрижки волос в его связи с традицией. Монголы называют этот обряд по-разному – удаление (стрижка) волос у детей и т.д. Этот ритуал существует на протяжении длительного времени и ярко отражен в памятниках героического эпоса. Для первого удаления “девственных” волос на голове ребенка монголы не используют металлические или острые ножи. Сначала они делают вид, что удаляют волосы деревянными ножницами, затем подстригают волосы в нужном направлении, начиная с правой стороны головы. Обривается почти вся голова ребенка за исключением небольшого пучка волос (тав). Каждый участник ритуала произносит благословение и делает подарок этому ребенку. Для первой стрижки волос выбирают благоприятный день. Ритуал превращается в небольшой праздник, в ходе которого восхваляют всех членов семьи и дальних родственников. Этот ритуал остается актуальным для современных монголов и привлекает внимание не только этнографов и фольклористов, но и исполнителей произведений устного народного творчества. Автору статьи удалось принять участие в ритуале первой стрижки волос у детей в семье представителей этнической группы западные халха в сомоне Уянга Увурхангайского аймака. Также автором был обнаружен еще один интересный факт, связанный с исследованиями, проведенными в том районе. В ходе анализа источников удалось выяснить, что в современном ритуале первой стрижки волос ребенка у народа халха сохраняются древние элементы. Для подтверждения своей гипотезы автор привел сведения из дополнительных источников, а также материалы экспедиции в сомон Цагаан-Овоо аймака Дорнод.

Ключевые слова: Девственные волосы, первая стрижка волос у детей, обряд стрижки, монгольские ритуалы и устные традиции.

Об авторе: **Аюушжав Алимаа**, заведующая сектором фольклора, Института языка и литературы Монгольской Академии наук (Монголия, 13330, Улан-Батор, Район Баянзурх, Энхтайван пр., 54А). ORCID 0000-0002-3533-2000 (alimaa\_mgl@yahoo.com).

## THE CULTURAL SIGNIFICANCE OF THE CEREMONY OF CUTTING THE HAIR OF KHALKHA CHILDREN IN MONGOLIAN AT THE PRESENT TIME

Ayuushzhav ALIMAA

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

Based on archival and new field materials, the article examines the ritual of first hair cutting in its connection with tradition. The Mongols call this rite in different ways - removing (cutting) hair from children, etc. This ritual has existed for a long time and is clearly reflected in the monuments of the heroic epic. For the first removal of "virgin" hair on a child's head, the Mongols do not use metal or sharp knives. First, they pretend to remove the hair with wooden scissors, then cut the hair in the right direction, starting from the right side of the head. Almost the entire head of the child is shaved, with the exception of a small tuft of hair (тав). Each participant in the ritual pronounces a blessing and makes a gift to this child. An auspicious day is chosen for the first haircut. The ritual turns into a small celebration, during which all family members and distant relatives are praised. This ritual remains relevant for modern Mongols and attracts the attention of not only ethnographers and folklorists, but also performers of folklore. The author of the article managed to take part in the ritual of the first haircut for children in a family of representatives of the Western Khalkha ethnic group in the Uyanga somon of Uvurkhangay aimag. The author also discovered another interesting fact related to the research conducted in that area. During the analysis of sources, it was possible to find out that ancient elements are preserved in the modern ritual of the first haircut of a child among the Khalkha people. To confirm his hypothesis, the author cited information from additional sources, as well as materials from the expedition to the Tsagaan-Ovoo sum of the Dornod aimag.

Key words: Virgin hair, children's first hair cut, haircut rite, Mongolian rituals and oral traditions.

About the author: **Ayuushzhav ALIMAA**, Head of the Folklore Sector, Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (54A, Enkhtayvan Ave, Bayanzurkh District, Ulaanbaatar, 13330, Mongolia). ORCID 0000-0002-3533-2000 (alimaa\_mgl@yahoo.com).